**Судлагдахуун - Хүн орчин**

**Бүлэг сэдэв**: Амьд ба амьгүй байгаль
**Ээлжит хичээлийн сэдэв**: Амьд ба амьгүй бие
**Хамрах хүрээ** : 2-р анги
**Хичээл заагч багш:** Б. Оюунчимэг Дэвшил сургууль
**Огноо:** 2012-11-13 **Хугацаа:** 35 минут
**Зорилго:** Амьд ба амьгүй биеийг таних, нэрлэх, ялгах чадварыг эзэмших
**Зорилт:** - Амьд ба амьгүй биеийг таних
-Амьд ба амьгүй биеийг нэрлэ
-Амьд ба амьгүй биеийг ялгааг **мэдэ**х

**Агуулга:**

| Мэдлэг | Чадвар |
|---|---|
| Амьд ба амьгүй биеийн ялгаа | Амьд ба амьгүй биеийг таних<br>Амьд биеийг нэрлэх<br>Амьд ба амьгүй биеийг ялгааг таних |

**Мэдлэг эзэмшилт:** Орчноо мэдрэхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар таньж мэдсэн төсөөлөл дээр тулгуурлана.

**Хичээлийн хэлбэр:** **Багаар**
**Хичээлийн явцын үнэлгээ: -Аман үнэлгээ**
-Алхам 5,6,8, 9 дээр дугтуйтай дүрсээс авч , дүгнэлт хэсэг дээр эвлүүлэн нэрлэж амьд ба амьгүй биеийн аль нь болохыг тодорхойлох.

**Хичээлийн төлөвлөлт:**

| **Алхам** | **Багшийн үйл ажиллагаа** | **Хугацаа** | **Сурагчийн үйл ажиллагаа** | **Суралцагчдаас гарах боломжит хариулт** | **Хэрэглэгдэхүүн** | **Арга** |
|---|---|---|---|---|---|---|
| Сэргээн санах, сэдэлжүүлэлт | Сайн байцгаана уу? Хүүхдүүдээ Өөрийгөө танилцуулна. | 1 | Сурагчид багштай мэндлээд сууна. | | | Ажиглах<br>Харьцуулах |
| | **Алхам-1**<br>Баавгай, бамбарууш 2-ын зургийг ажиглаарай., Энэ 2-ын ялгаа нь юу вэ? | 2 | Сурагчид ялгааг нэрлэнэ. | -Баавгай бол:<br>-Амьд амьтан,<br>-Гараа өргөсөн байна<br>-Том биетэй байна<br>- Бамбарууш бол<br>-Бид нарын тоглодог тоглоом<br>- Жижиг биетэй,<br>-Чихмэл тоглоом<br>-Амьгүй байна | Баавгай, бамбарууш хоёрын зурагтай дэлгэцийн үзүүлэн<br>Баавгай нь хөдөлгөөнтэй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Алхам 2**<br>Хичээлийн сэдэв, зорилго, зорилтоо таниулна. | 2 | Хичээлийн сэдэв дэвтэртээ бичнэ. | | | |
| | **Алхам 3**<br>Бидний эргэн тойронд байгаа зүйлсийг ажиглаад нэрлээрэй. | 2 | Хүрээлэн буй орчны зүйлсийг нэрлэнэ. | Ж нь: цэцэг, хүн, багш, хүүхэд ,ширээ, сандал, ном дэвтэр гм | Самбар шохой | Нэрлэх<br>Ажиглах |
| | **Алхам 4**<br>Хүүхдүүдийн нэрлэсэн үгнүүдийг амьд ба амьгүй биеэр нь ялгуулан нэрлүүлж самбарт бичнэ. | 2 | Амьд бие: Хүн<br>Хүүхэд<br>Амьтан<br>Цэцэг<br>Амьгүй бие: Ширээ<br>Үзэг<br>Сандал<br>бөмбөг | Амьд бие: Хүн<br>Хүүхэд<br>амьтан<br>Амьгүй бие: Ширээ<br>Үзэг<br>Сандал<br>Цэцэг<br>бөмбөг | | Ажиглах<br>Нэрлэх |
| Шинэ мэдлэг бүтээх үе | **Алхам 5**<br>Багуудад зураг тарааж өгөх.<br>Эдгээр зургуудыг амьд амьгүйгээр нь ялгаж самбарт байрлуулаарай. \| Мод, байшин, заан, сурагч, цэцэг, алх, үзэг, ширээ, машин, бөмбөг, шувуу, өвөө, \| | 5 | Амьд<br>Сурагч<br>Өвөө<br>Мод<br>Цэцэг<br>Шувуу<br>заан<br>Амьгүй<br>Бөмбөг<br>Машин, байшин, алх, сүх ширээ, үзэг | Амьд бие<br>Сурагч<br>хүүхдүүд<br>Өвөө<br>Цэцэг<br>Шувуу<br>Заан<br>Амьгүй бие<br>Бөмбөг<br>Машин, байшин, алх, сүх ширээ, үзэг<br>Мод<br>цэцэг | Зураг<br>Төм | Ангилах, ялгах, харьцуулах<br>Ажиглах |
| | **Алхам 6**<br>Хүн \| Амьтан \| Ургамал \| Бусад зүйл<br>Амьд бие \| Амьгүй бие<br>Онцлог<br>Ажлын том хуудас тарааж өгөн багаар ярилцуулж бичүүлнэ.<br>Бичсэн зүйлээ шалгаж хүн бүр жижиг хуудас бөглөнө гэдгийг тайлбарлана. | 10 | Багшийн зааврын дагуу ажлын хуудсан дээр зургуудыг, ялган бичнэ<br>Хүн: Хүүхэд, өвөө<br>Амьтан: заан, шувуу<br>Ургамал: Цэцэг, мод<br>Бусад зүйл: Бөмбөг, алх, Байшин ширээ үзэг<br>Амьд бие: Хооллодог Хөдөлдөг Явдаг<br>Амьгүй бие: Хооллодог-гүй Хөдөлдөггүй явдаггүй | Хүн: Хүүхэд, өвөө<br>Амьтан: заан, шувуу<br>Ургамал: Цэцэг, мод<br>Бусад зүйл: Бөмбөг, алх, Байшин ширээ үзэг<br>Амьд бие: Хооллодог Хөдөлдөг явдаг<br>Амьгүй бие: ХооллодогГүЙ Хөдөлдөггүй явдаггүй | Ажлын хуудас Том, жижиг 2 ширхэг | Багаараа хамтарч ярилцах, санал бодлоо солилцох, дүгнэлт гаргах |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Алжаал тайлах дасагл | **Алхам 7**<br>Тоглоомын зааврыг багш тайлбарлана.<br>Амьд биеийг нэрлэхэд босож зогсоод тухайн амьтны хөдөлгөөн хийх, эсвэл дуу авиа гаргана. Амьгүй биеийг нэрлэхэд сандал дээр сууна. | 2 | Сурагчид зааврын дагуу тоглоомонд идэвхтэй оролцоно. | Сурагчид амьд, амьгүй биеийг сольж босож, суух алдаа грагаж болно. | | Тоглоомын арга |
| Бататгал | **Алхам 8**<br>Баг бүрт шоо тараан өгч тоглоом тоглуулах,<br>Тоглоомын заавар<br>Сурагчид шоог ээлжлэн орхино.<br>Шооны тоонд харгалзсан зургийг тайлбарлана. \амьд бие, амьгүй бие\ | 3 | Шоо орхин шооны тоонд харгалзсан зургийг тайлбарлана. | Мод- амьд<br>Хэрэм-амьд<br>Хүүхэд-амьд<br>Цэцэг- амьд<br>Үүл- амьгүй<br>Нар- амьгүй | Шоо, сурах бичиг, | Тоглоомын арга, шооны арга |
| Дүгнэлт | **Алхам 9**<br>Хиймэл цэцэг ба тасалгааны цэцэг 2-ыг ажиглуулан амьд ба амьгүй биеийг ялгуулах Яагаад? | 5 | Сурагчид 2 цэцгийг ажиглан ярилцаж аль цэцэг нь амьд, аль цэцэг нь амьгүй болохыг ялгана.<br>Яагаад гэвэл гээд сурагчид тасалгааны цэцэг нь амьсгална, хооллоно, өснө | Тасалгааны цэцэг –амьд<br>Хиймэл цэцэг -амьгүй | Тасалгаа ны цэцэг, хиймэл цэцэг | Ажиглуулах<br>Харьцуулах<br>Тайлбарлах |
| Гэрийн даалгавар | **Алхам 10**<br>Сонгох харгалзуулах тест сурагчдад тараан өгнө.<br>1 Дараах үгсээс амьд биеийг ялган зураарай.<br>Ширээ, ном, нохой, үзэг, уул, цэцэг<br>2 Зөв харгалзуулаарай.<br>А. Муур 1. Амьгүйбие<br>Б. Чулуу 2. Амьд бие | 1 | Тест ажиллах | 1 Дараах үгсээс амьд биеийг ялган зураарай.<br>Ширээ, ном, **<u>нохой,</u>** үзэг, уул, **<u>цэцэг</u>**<br>2 Зөв харгалзуулаарай.<br>А. Муур 1. Амьгүйбие<br>Б. Чулуу 2. Амьд бие | | Бод хамтар хуваалц, харилцан яриа |
| | Цэцгийг яагаад усалдаг вэ? | 1 | Бичиж тэмдэглэнэ. | | | |
| | **Дүн** | 35 | | | | |

Багийн гишүүд:

| | | | |
|---|---|---|---|
| Д. Цэрэндорж | Говь-Алтай | Э. Эрдэнэ-Оюун | Ховд |
| Э. Дуламханд | Увс | Д.Аселбек | Баян-Өлгий |
| Ш. Цэндхүү | Ховд Их Сургууль | Ж. Баярмаа | Сонгино |
| В. Долгорсүрэн | Тосонцэнгэл | Л. Болормаа | Завханмандал |
| Б. Хишигмөнх | Баянтэс | Б. Оюунчимэг | Дэвшил сургууль |
| У. Алтанцоож | ЧЭЦ сургууль | Х. Серикбол | Баян-Өлгий |
| Д.Энэсайн | Шилүүстэй | Д. Цэвэгээ | Говь-Алтай |

**Зорилт:**
-Амьд ба амьгүй биеийг таних:
-Амьд ба амьгүй биеийг ялгаж чаддаг болох